



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 81

Номгон

Эзэмшигч тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 а, в дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймагт Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр бэлтгэсэн 2 нэрийн 108 621 560 төгрөгийн хөрөнгүүдийн эзэмшигчийг нэгдүгээр, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2 нэрийн 103 975 000 төгрөгийн орон сууцны барилгын эзэмшигчийг хоёрдугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

2. Эзэмшигч тогтоосон нийтийн эзэмшлийн талбай, авто зам, явган хүний зам, автомашины зогсоол, мод бут сөөг, гудамж, гэр хорооллын гэрэлтүүлгийн цахилгааны төлбөр, түүний арчлалт, хадгалалт, хамгаалалт, засвар үйлчилгээний зардлыг эзэмшигч тогтоосон тухай бүр тооцон гаргаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар төсвийн зардлыг нэмэгдүүлж батлуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Эзэмшигч тогтоосон хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



0117193

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны  
өдрийн 81 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР  
БИЙ БОЛСОН ХӨРӨНГӨД ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлсэн төслийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Гэрээний дүн /мян.төг/	Бүртгэлд тусгах дүн /мян.төг/	Хөрөнгийн эх үүсвэр	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Улсын комисс хүлээн авсан эсэх	Эзэмшигч байгууллага	Тайлбар
1	Гурван бүс цогцолборын явган хүний зам 356.5 м2 талбайтай, автомашины зогсоол 714 м2	м2	1070.5	80000000	80000000	ОНХС	Иргэн М.Эрдэнэбилэг	Авсан	"Хот тохижилт" ОНӨҮГ	Гурван бүс цогцолборын баруун талын хашаанаас зам хүртэл өнгөгүй саарал тоосгоор хийсэн зам нь урт 200мх өргөн 4.4 м= 88м2 талбайтай, хашааны үзүүр хүртэл хуучин явган замтай нийлэх хүртэл урт 12мх өргөн 1.5=18 м2 зам байна. хашааны зүүн талаар явсан явган хүний зам урт 167* өргөн 1.5 м= 250.5 м2 замтай, зүүн талдаа өргөн 15мх урт 47.6= 714м2 талбай бүхий машины зогсоолд хэмжилт хийсэн.
2	Цэвэр усны байгууламжийн хяналтын камер	Е	5	28621560	28621560	ОНХС	"Сектек сервис" ХХК	2014.10.27 хүлээн авсан	"Чандмань-Баянхонгор" ХК	Усны эх үүсвэр дээр /Эрдэнэцогт явдаг гарам/ 4 ширхэг, Хөх толгойн даралтын усан санд 1 ширхэг, хяналтын камерийг суурилуулсан. Камерийн серверийн програм хангамж Цагдаагийн газарт байдаг бөгөөд шууд татаж хардаг.
	Нийт дүн			108621560	108621560					



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 16-ны  
өдрийн 81 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХУДАЛДАН  
АВСАН ОРОН СУУЦАНД ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүртгэлд тусгах дүн /мян.төг/	Хөрөнгийн эх үүсвэр	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Улсын комисс хүлээн авсан эсэх	Эзэмшигч байгууллага	Тайлбар
1	2 ерөө орон сууц	М2	927,246.79	52,000,000	Орон нутгийн төсөв	Зоригтболд ХХК	авсан	Аймгийн ЗДТГ	Номгон 1-р баг 3 шарын замын эсрэг талд 99-р байр 5 давхар 1 орцтой байрны 5 давхарт 27 тоот. Гал тогоо зочны өрөө цуг, унтлагын өрөөтэй, ванн оо-ийн өрөө хамт
2	2 ерөө орон сууц	М2	945,000.00	51,975,000	Орон нутгийн төсөв	Эх бүрдэн ХХК	авсан	Аймгийн ЗДТГ	Дуурсах 3-р баг Петровис шатахуун түгээх станцын баруун талд 34-р байр зам руу харсан 2 орцтой байрны 2 дугаар орц 5 давхарт 37 тоот. Гал тогоо зочны өрөө цуг, унтлагын өрөөтэй, ванн оо-ийн өрөө хамт
	Нийт дүн			<b>103,975,000</b>					